



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 1/01

Баян-Өндөр сум

Менингококкт халдварын бэлэн байдал, эмчилгээ, оношилгоо, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.4, 8.1.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2008 оны 2008 оны "Менингококкт халдвартай тэмцэх, сэргийлэх, оношилгоо, эмчилгээний заавар батлах тухай" 37, 2024 оны "Тууралтат халдварт өвчний эмнэлзүйн заавар батлах тухай" 91 дүгээр тушаал, 2025 оны "Менингококкт халдварын бэлэн байдал, эмчилгээ, оношилгоо, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай" 01 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Менингококкт халдвар бүртгэгдсэн тохиолдолд хариу арга хэмжээг зохион байгуулах мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, менингококкт халдварын бэлэн байдал, эмчилгээ, оношилгоо, хариу арга хэмжээг эрчимжүүлэх төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Менингококкт халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ, лабораторийн урвалж, оношлуур, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, өвчний хүндрэл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх, хүн амын дунд халдвар тархахаас сэргийлэх мэдээлэл сурталчилгааг зохион байгуулж ажиллахыг мэргэжлийн багийн дарга, гишүүд болон бүх шатны эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв (А.Ганчимэг)-т даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны
01 сарын 08 -ны өдрийн
А/01 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

9043446 2020030036

Менингококкт халдвар бүртгэгдсэн тохиолдолд хариу арга хэмжээг
зохион байгуулах мэргэжлийн багийн бүрэлдэхүүн

Багийн дарга:

П.Отгонбилэг - Дархлаажуулалт, зоонозын халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

П.Хишгээ - Эмнэлгийн тусламжийн чанар эрсдэл магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Солонго - Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч

Б.Будсүрэн - Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч

А.Хонгорзул - Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, ахмад настны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Д.Цэрэнлхам - Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Ч.Мөнхзул - Эмнэлгийн дотоод халдвар хариуцсан мэргэжилтэн

Б.Цэндбаяр - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн халдвартын тасгийн эрхлэгч

Б.Хулан - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тархвар судлаач



Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны
01 сарын 01-ны өдрийн
Ажлын дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

МЕНИНГОКОККТ ХАЛДВАРЫН БЭЛЭН БАЙДАЛ, ЭМЧИЛГЭЭ, ОНОШИЛГОО,
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХЭМЖЭЭНД				
1	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтнуудад Эрүүл мэндийн сайдын 2008 оны 37 дугаар тушаалаар батлагдсан "Менингококкт халдвартай тэмцэх, сэргийлэх, оношилгоо, эмчилгээний заавар", 2024 оны 91 дүгээр тушаалаар батлагдсан "Тууралтат халдварт өвчний эмнэлзүйн заавар"-ын хэрэгжилтийг хангах сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулах	1 сард	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
2	Менингококкт халдвар бүртгэгдсэн тохиолдолд хариу арга хэмжээг зохион байгуулах мэргэжлийн багийг чадавхжуулах, бэлэн байдлыг хангах	1 сард	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
3	Менингококкт халдварыг эрт илрүүлэх арга хэмжээг зохион байгуулан, халдвар бүртгэгдсэн тохиолдолд тухай яаралтай мэдээлж, эрсдэлийн үнэлгээг хийж, хариу авах арга хэмжээ авах	Тухай бүр	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв	ХӨСҮТ
4	Орон нутгийн удирдлага болон холбогдох салбарын мэргэжилтэн, сэтгүүлч нарт эрсдэлийн үеийн мэдээллийг тогтмол хийх.	2 сард	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв	АЗДТГ
5	Менингококкт халдварын оношилгооны урвалж, оношлуур, сорьц цуглуулах хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, голомтод хэрэглэх эм (ципрофлаксамин, рифампицин), халдваргүйжүүлэх бодисын нөөц, хэрэгцээнд үнэлгээ хийж, холбогдох зардлыг сум, өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төсөвт тусгах	1 сард	Эрүүл мэндийн газар Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтэс	Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төв

	арга хэмжээг зохион байгуулах				
6	Менингококкт халдвараас сэргийлэх талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бусад мэдээлэл сурталчилгааны аргыг ашиглан хүн амыг үнэн, бодит мэдээллээр шуурхай хангаж, тогтмол түгээж, бүх зорилтот бүлэгт мэдээлэл хүрч байгаа эсэхэд 14 хоног тутамд үнэлгээ хийж, зохих арга хэмжээг зохион байгуулах	Тогтмол	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв	Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төв	
7	Хүүхдийн байгууллагад ирцийн тандалтыг хийн өвчлөлийн нөхцөл байдалтай уялдуулан дүгнэлт хийж, мэргэжил арга зүйгээр ханган, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн баг томилон ажиллуулах	1-6 сард	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв	Боловсролын газар	
ХОЁР. БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВД					
8	Менингококкт халдварыг эрт илрүүлэн, урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа, оношилгоо, эмчилгээ, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг хангаж, холбогдох тушаал, журмыг хэрэгжүүлэх	Тогтмол	Бүсийн оношилгоо* эмчилгээний төв	Эрүүл мэндийн газар Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтэс	
9	Менингококкт халдварын тохиолдлыг тусгаарлан эмчлэх тасгийн бэлэн байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах	Тогтмол	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Эрүүл мэндийн газар Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтэс	
10	Халдварын сэргийлэлт, хяналтын багийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, эмнэлгийн тусламж үйлчилгээнд халдвар хамгааллын дэглэмийг чандлан баримталж, хяналт тавих	Тогтмол	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Эрүүл мэндийн газар Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтэс	
11	Түргэн тусламжийн дуудлагыг ангилан өндөр халуурсан, арьсаар тууралт гарсан, бөөлжсөн, таталт өгсөн гэсэн өгүүлэмжтэй дуудлагад эмнэлгийн тусламжийг хугацаа алдалгүй үзүүлэх, эмнэлэг хооронд түргэний машинаар тээвэрлэх, эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэхдээ өвчтөний аюулгүй байдлыг хангах	Тогтмол	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Эрүүл мэндийн газар Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтэс	
12	Нян судлалын лабораторийн урвалж, оношлуур, сорьцын материал, тоног төхөөрөмж, голомтод хэрэглэх эм (ципрофлаксацин, рифампицин), эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэх бодисын нөөц, хэрэгцээг тогтмол үнэлж, холбогдох зардлыг жил бүрийн төсөвт тусгах, тасралтгүй байдлыг хангах	Тогтмол	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Эрүүл мэндийн газар Удирдлага төлөвлөлтийн хэлтэс	

13	Менингококкт халдварын сэжигтэй өвчтөнд антибиотик эмчилгээ эхлэхээс өмнө цус, тархи нугасны шингэний сорьц авч нян судлалын лабораторид үүсгэгчийн хүрээ, дэд хүрээг тодорхойлж, оношийг лабораториор баталгаажуулан, эерэг тодорхойлогдсон өсгөврийг ХӨСҮТ-ийн Нян судлалын лавлагаа лабораторид илгээж, баталгаажуулах	Тухай бүр	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	ХӨСҮТ
14	Хэвтэн эмчлүүлэгч, эрүүл мэндийн байгууллагын ажилчдын дунд менингококкт халдварын хамшинж, нян судлалын лабораторид эмнэлзүйн сорьцоос <i>Neisseria meningitides</i> илэрсэн тохиолдолд тохиолдолд яаралтай тусгаарлан, халдвартын тасагт шилжүүлж, 1 цагийн дотор Эрүүл мэндийн газарт мэдээлэх	Тухай бүр	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв
15	Менингококкт халдварын оношилгоо, эмчилгээ, тандалт, халдварын сэргийлэлт, хяналт, сорьц авах, хадгалах, тээвэрлэх, шинжилгээний дүнг үнэлэх чиглэлээр чиглэлээр эмч, эрүүл мэндийн ажилчдад тогтмол сургалт зохион байгуулж, чадавхжуулах	1 сард	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв
ГУРАВ. СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД:				
16	Менингококкт халдварын сэжигтэй тохиолдолд нэн тэргүүнд эмнэлгийн тусламж үзүүлж, өвчтнийг тусгаарлах, халдвартын тасагт хүргэх	Тухай бүр	Сум, өрхийн эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв
17	Менингококкт халдварын сэжигтэй тохиолдол бүртгэгдвэл Эрүүл мэндийн газарт 1 цагийн дотор шуурхай мэдээлж, тандалт судалгаа, хариу арга хэмжээг холбогдох мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулах;	Тухай бүр	Сум, өрхийн эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв
18	Менингококкт халдвараас сэргийлэх талаар харьяа нутаг дэвсгэрийн хүн ам болон хүүхдийн байгууллагад зориулсан сургалт, сурталчилгааг тогтмол хийх	Тогтмол	Сум, өрхийн эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв
19	Менингококкт халдварын оношилгоо, эмчилгээ, тандалт, халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр эмч, эрүүл мэндийн ажилчдад тогтмол сургалт зохион байгуулах, чадавхжуулах.	1 сард	Сум, өрхийн эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв
ДӨРӨВ. ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД:				
20	Менингококкт халдварын сэжигтэй тохиолдолд нэн тэргүүнд	Тогтмол	ХХЭМБ-ын Чандмань-	Эрүүл мэндийн газар

	эмнэлгийн тусламж үзүүлж, өвчтөнийг тусгаарлах, анхан шатны эмнэлгийн тусламжийг үзүүлж, өвчтөний биеийг тогтворжсоны дараа дараагийн шатны эрүүл мэндийн байгууллага руу шилжүүлэх		Эрдэнэ холбоо	Нийгмийн эрүүл мэндийн төв
21	Менингококкт халдварын сэжигтэй тохиолдол бүртгэгдвэл дээд шатны байгууллагад 1 цагийн дотор шуурхай мэдээлж, тандалт судалгаа, хариу арга хэмжээг дээд шатны байгууллагын холбогдох мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулах	Тогтмол	ХХЭМБ-ын Чандмань-Эрдэнэ холбоо	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв
22	Менингококкт халдварын оношилгоо, эмчилгээ, тандалт, халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр эмч, эрүүл мэндийн ажилтнуудад тогтмол сургалт зохион байгуулах, чадавхжуулах	Тогтмол	ХХЭМБ-ын Чандмань-Эрдэнэ холбоо	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв
23	Хүн амд амны хаалт хэрэглэх, гарын ариун цэвэр сахиx, хүн хоорондын зай барих, өрөө тасалгааны агааржуулалтыг сайжруулах гэх мэт халдвараас сэргийлэх энгийн аргуудын үр дүнг сурталчилж, хувь хүн, байгууллага, хамт олны үүрэг оролцоог нэмэгдүүлэх	Тогтмол	ХХЭМБ-ын Чандмань-Эрдэнэ холбоо	Эрүүл мэндийн газар Нийгмийн эрүүл мэндийн төв